

12

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ,
ЦААШДЫН ХАНДЛАГА**

А. Энхбат

Монгол улс 1990 оноос эхлэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжин орсноос хойш бүтэн 10 жилийн хугацаа өнгөрч байна. Энэхүү 10 жилийн хугацаан дахь Монгол улсын эдийн засгийн хөгжлийн ололт амжилт, бууралт онцлог шинж чанарууд, зах зээлийн эдийн засгийн шилжилтийн хүндэрлэл бэрхшээлд дүн шинжилгээ хийж дүгнэлт өгөх зайлшгүй шаардлагатай бөгөөд нөгөө талаар ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг макро-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээр тодорхойлох, цаашид тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангахын тулд эдийн засгийн ямар бодлого, чиглэл, арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаа зэрэг маш олон асуудлуудад хариулт өгөх үе бидний өмнө тулгарч ирээд байна.

**Нэг. Өнгөрсөн 10 жилийн макро-эдийн засгийн
байдлын талаархи товч дүн шинжилгээ**


Монгол улс 1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 30 хүртэл хувьтай тэнцэх татаас, зээл, тусламжийг социалист системийн улсуудаас авдаг байсан. Энэхүү татаас зогссон үед манай улс эдийн засгийн гол чиглэл баримтлалаа зах зээлийн эдийн засгаар сольж шинэчлэлт хийсэн билээ. Энэхүү зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үе шатанд эдийн засгийн маш олон хүнд асуудлуутай тулгарч байсан. Тухайлбал: ажилгүйдэл, мөнгөний ханш бууралт, төсвийн алдагдал, банкуудын дампуурал болон найдваргүй үйл ажиллагаа, улсын үйлдвэрийн газруудын үйлдвэрлэлийн уналт, өмч хувьчлал, үнийн чөлөөлөлт, нийгмийн хамгааллын асуудал гэх мэт. Өнгөрсөн 10 жилийн хугацааг эргэн харахад манай улсын зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийг үндсэн турван үе шатанд хувааж үзэж болно гэж би үзэж байна. Үндэхийн үе шат бол 1990-ээс 1993 оныг хүртэл хугацаа хамрагдах бөгөөд энэ үеийг тогтвортгүй болон удаан сул эдийн засгийн хөгжлийн үе, хоёр дахь үе шат

бол 1994-1996 оныг хамрагдах бөгөөд макро-эдийн засгийн тогтвортгилтын болон эдийн засгийг нөхөн сэргээх эхний үе шат, гурав дахь үе шат бол 1997-2000 оныг хүртэлх хугацаа хамрагдах бөгөөд энэ үеийг макро-эдийн засгийн тогтвортгилт болон эдийн засгийг нөхөн сэргээх хоёр дахь үе шат гэж нэрлэж болно. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн дээрхи 3 үе шатанд хамрагдах хугацаан дахь макро-эдийн засгийн байдлыг товчон авч үзье.

1.1. Тогтвортгүй болон удаан, сул эдийн засгийн хөгжлийн үе (1990-1993)

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ маань 1990 онд 2,5 хувь, 1991 онд 9,2 хувь, 1992 онд 9,5 хувь, 1993 онд 3 хувь хүртэл (Зураг 1) тус тус буурсны зэрэгцээ энэ 4 жилийн хугацаанд үндэсний орлого маань 20 хувь хүртэл, бодит хувийн хэрэглээ маань гурав дахин, хөрөнгө оруулалтын хэмжээ хоёроос гурав дахин буурсан. Эдгээр үзүүлэлтүүд буурсан үндсэн гол шалтгаанууд бол хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл үндсэндээ зогсолтын байдалд орж жил тутам буурч байсан, мөн улсын төсвийн орлого буурахын зэрэгцээ зарлага ёссен, маш хурдацтай мөнгөний ханш бууралт зэрэг зүйлүүд нөлөөлж байсан. Тодорхой жишээ татах юм бол ганцхан 1991 онд бодит дотоодын нийт

Зураг 1



бүтээгдэхүүний хэмжээ маань 9,2 хувиар буурсан. Үүний гол шалтгаан нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жингээр 15,2 хувиас 14,1 хувь хүртэл, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 35,6 хувиас 30,2 хувь хүртэл, барилгын үйлдвэрлэл 5,0 хувиас 4,0 хувь хүртэл, тээвэр холбооны салбарын үйлдвэрлэл 12 хувиас 6,7 хувь хүртэл унасан байна.

Макро-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээр авч үзэх юм бол 1990 онд экспортын нийт хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүний 35,5 хувь эзлэж байсан бол 1991 онд 17,5 хувь хүртэл хоёр дахин буурсан байх жишээтэй. Экспортын хэмжээ буурсан гол шалтгаан нь зэсийн баяжмалын экспорт дотоодын нийт бүтээгдэхүүний 14,0 хувиас 10,7 хувь хүртэл буурсан байна. Мөн импортын хэмжээ 49,7 хувиас 18,2 хувь хүртэл, Засгийн газрын хэрэглээ 29,8-иас 25,1 хувь хүртэл, хувийн болон засгийн газрын хөрөнгө оруулалт тус тус хоёр дахин буурсан байна.

Улсын төсөв

Улсын төсвийн нийт алдагдал 1990-1992 оны хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувьтай тэнцэж байсан нь төсвийн орлогын огцом бууралттай холбоотой байсан.

Хүснэгт 1

Монгол улсын төвлөрсөн төсөв (ДНБ-нд эзлэх хувиар)

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998
Нийт орлого Үргслат орлого Хөрөнгийн орлого	47.4 47.4	30.0 30.0	34.7 32.9	31.0 1.8	33.7 1.4	27.8 2.1	29.3 2.1	27.4 24.8 2.6
Нийт зарлага Үргслат зарлага Хөрөнгийн зарлага	57.1 51.7 5.4	42.7 31.1 11.6	52.5 27.0 25.5	44.2 26.4 27.8	40.4 23.7 16.7	36.0 22.1 13.9	37.9 25.4 12.5	39.1 25.4 13.7
Үргслат тэнцэл	-4.3	-1.1	5.9	3.2	8.0	4.5	1.8	-0.6
Нийт тэнцэл	-9.7	-12.7	-17.7	-13.3	-6.7	-8.2	-8.6	-11.7
Санхүүжилт Гадаад, цэвэр Дотоод	9.7 9.7 -	12.7 11.2 1.5	17.7 13.4 4.3	13.3 8.5 4.8	6.7 5.6 1.1	8.2 6.0 2.2	8.6 12.2 -3.6	11.7 7.8 .8

Засгийн газрын төсвийн алдагдлын хэмжээ 1990-иэс 1993 оныг хүртэлх хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 9,7 хувиас 16,1 хувьтай тэнцэх хүртэл хэмжээнд байсан байна. Энэ хугацаанд засгийн газрын төсвийн нийт орлого дотоодын нийт бүтээгдэхүүний 50,6 хувиас 33,3 хувь хүртэл нийт зарлага 64,1 хувиас 49,4 хувь хүртэл буурсан.

Төлбөрийн тэнцэл

Экспортын хэмжээ 1990 оноос 1993 оныг хүртэлх хугацаанд 660,7 сая ам. доллараас 365,8 сая ам. доллар хүртэл буурсны зэрэгцээ импортын хэмжээ 924 сая ам. доллараас 374,5 сая ам. доллар хүртэл буурсан бөгөөд гадаад худалдааны алдагдал 29,9 сая ам. доллараас 263,3 сая ам. доллар хүртэл ёссөн байна. Ганцхан 1993 онд гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан.

1.2. Макро-эдийн засгийн тогтвортой болон эдийн засгийг нөхөн сэргээх эхний үе шат (1994-1996)

Манай улсын макро-эдийн засгийн тогтвортойлийн эхний үе шат үндсэндээ 1994 оноос эхэлсэн гэж үзэж болохоор байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит ёсөлт 1994 онд 1989 оноос хойш анх удаа 2,3 хувь, 1995 онд 6,3 хувь, 1996 онд 2,4 хувь болтол ёссөн. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит ёсөлт ёсөхөд нөлөөлсөн үндсэн гол хүчин зүйлүүд нь хандивлагч донор орнуудаас Монгол улсын эдийн засагт үзүүлж байсан зээл, тусlamжийн үйл ажиллагаа эрс идэвхижсэн бөгөөд манай улс энэхүү зээл, тусlamжийг үр ашигтай ашиглаж байсан, мөн өмч хувьчлал, хувийн хэвшилийн секторын хөгжилтэй холбоотой юм. Үүний үр дүнд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 1997-1999 онд 2,9 хувиас 4,4 хувь хүртэл, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 1997 онд 4,8 хувь, 1998, 1999 онуудад 3,1 хувь, тус тус ёссөн байна. 1997-1999 оны хугацаанд нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний ёсөлт зэрэгцүүлсэн үнээр ойролцоогоор 2 хувьтай

дэд бүтэц, эрчим хүчний салбар, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлүүдийг сэргээх төслүүдийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой.

Энэ хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ёсөлтийн хэмжээ 1994 онд 1,7 хувь, 1995 онд 17,4 хувь ёссөн, харин 1996 онд 2 хувиар буурсан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 1994 онд 2,7 хувь, 1995 онд 9,5 хувь 1996 онд 4,7 хувь, тус тус ёссөн байна. Хэрэглээний үнийн индекс дунджаар 1994 онд 66,2 хувь байсан бол 1996 онд 44,6 хувь хүртэл буурсан байна.

Улсын Төсөв

Улсын төвлөрсөн төсвийн нийт орлого энэ хугацаанд дунджаар Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жингээр 27,8-аас 33,7 хүртэл хувь хэмжээнд байсан ба төсвийн нийт зарлага мөн 36,0-иас 44,2 хувь хэмжээнд байсан байна. Төсвийн алдагдал 1994 оноос 1996 оны хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 6,7 хувиас 17,7 хувь хүртэл хэмжээнд байсан. Төсвийн алдагдлыг гадаадын зээл, тусlamж болон дотоодын хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж байсан бөгөөд энэ нь гадаад эх үүсвэрээр 6,0 хувиас 13,4 хувь хүртэл, дотоодын цэвэр зээлээр 1,1 хувиас 4,8 хувь хүртэл хэмжээнд байсан байна.

Төлбөрийн тэнцэл

Манай улсын гадаад худалдааны тэнцэл 1994 онд 7,9 сая ам. долларын алдагдалтай байсан бол 1995 онд 48,5 сая ам. долларын ашигтай гарсан байна. Гэвч 1996 онд 35,0 сая ам. долларын алдагдалтай гарсан нь экспортын хэмжээ урьд оныхтой харьцуулахад 61,6 сая ам. доллараар буурч, импортын хэмжээ 21,9 сая ам. доллараар ёссентэй холбоотой бөгөөд экспорт буурсан гол шалтгаан нь 1996 онд дэлхийн зэсийн зах зээлийн үнэ эрс унасантай шууд хамаарлтай.

1.3. Макро-эдийн засгийн тогтвортой болон эдийн засгийг нөхөн сэргээх хоёр дахь үе шат (1997-2000)

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний ёсөлт 1997 онд 4,0 хувь, 1998 онд 3,5 хувь, 1999 онд ойролцоогоор 3,5 хувь тус тус ёссөн байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь хандивлагч донор орнуудаас Монгол улсын эдийн засагт үзүүлж байсан зээл, тусlamжийн үйл ажиллагаа эрс идэвхижсэн бөгөөд манай улс энэхүү зээл, тусlamжийг үр ашигтай ашиглаж байсан, мөн өмч хувьчлал, хувийн хэвшилийн секторын хөгжилтэй холбоотой юм. Үүний үр дүнд дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 1997-1999 онд 2,9 хувиас 4,4 хувь хүртэл, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 1997 онд 4,8 хувь, 1998, 1999 онуудад 3,1 хувь, тус тус ёссөн байна. 1997-1999 оны хугацаанд нэг хүнд ногдох Дотоодын нийт бүтээгдэхүүний ёсөлт зэрэгцүүлсэн үнээр ойролцоогоор 2 хувьтай

байсан бөгөөд энэ хугацаанд хувийн хэрэглээ дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жингээр дундажаар 60 хувь, Засгийн газрын хэрэглээ дундажаар 16-17 хувтай байсан байна.

Улсын төсөв

Улсын төвлөрсөн төсвийн нийт орлого 1997 онд дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан хувиар 29,3 байсан ба харин 1998, 1999 онуудад энэ хувь буурч улмаар 27,4 хувь, 26,4 хувь тус тус буурсан байна. Харин улсын төвлөрсөн төсвийн зарлага 1997 онд 37,9 хувь байсан ба улмаар 1998 онд энэ нь ёсч 39,1 хувь, 1999 онд 38,7 хувь хүртэл буурсан байна. Улсын төвлөрсөн төсвийн нийт тэнцэл буюу алдагдал нь 1997 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 8,6 хувь, 1998, 1999 онуудад тус тус 11,7 хувь, 12,3 хувь хүртэл ёссөн байгаа юм. Энд нөлөөлсөн хүчин зүйлүүд нь улсын төсвийн урсгал орлого болон татварын орлогууд буурсантай холбоотой юм.

Төлбөрийн тэнцэл

Гадаад худалдааны тэнцэл ашигтай байсан буюу экспортын хэмжээ 17 хувиар ёссөн учраас гадаад худалдааны урсгал тэнцэл ашигтай гарсан ба энэ нь 1997 онд 95,8 сая ам. доллар байсан. Харин 1998, 1999 онуудад энэ нь гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарсны улмаас гадаад худалдааны урсгал тэнцэл буурч улмаар алдагдалтай болсон. Үүнд нөлөөлсөн хүчин зүйлүүд нь экспортын хэмжээ буурч импортын хэмжээ маань ёссентэй холбоотой юм.

Хоёр. Монгол улсын макро-эдийн засгийн цаашдын чиг хандлага, эдийн засгийн загварчлал

Монгол улсын макро-эдийн засгийн хөгжлийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоходоо өнгөрсөн хугацаан дахь эдийн засгийн бодит тоон дээр тулгуурлан эдийн засгийн загварчлал (model)-ыг ашигласан бөгөөд энэхүү загварчлал нь өнөөдөр дэлхийн нийтэд хэрэглэгддэг загварчлалуудын нэг юм.

Дэлхийн банк 10-аад жилийн өмнөөс RMSM (Revised Minimum Standard Model) – аргыг боловсруулан хөгжих буй орнуудын эдийн засгийн өсөлтийн чиг хандлагад дүн шинжилгээ, төсөөлөл хийж ирсэн. Энэхүү загварчлалын гол цөм бол үйлдвэрлэлийн нийт хэмжээ буюу дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцож түүн дээр үндэслэн нийт хөрөнгө оруулалт буюу капиталын хэмжээ (Harrod-Domar model)-г гаргадаг. Загварчлал нь үндсэн турван хэсгээс бүрддэг бөгөөд нэгдүгээрт загварын динамик хэсэг, хоёрдугаарт статик хэсэг, гуравдугаарт гадаад өрийн хэсэг байдаг. Би энэхүү хэсэгтээ эдийн засгийн онолын эдгээр хэсгийг дурьдалгүйгээр зөвхөн загварчлалд тооцсон макро-эдийн засгийн үндсэн гол үзүүлэлтүүдийн төсөөлөл болон энэхүү судалгаагаар гарсан үр дүнг тайлбарлай.

Энэхүү загварчлалаар Монгол улсын макро-эдийн засгийн сүүлийн 10 жилийн хугацаанд дүн шинжилгээ хийж, гарсан бодит тоонууд дээр үндэслэн дотоодын нийт

бүтээгдэхүүний тогтвортой бодит ёсөлт болон гадаад зээл, экспортын өсөлтийн төсөөлөл хийж цаашдын 40 жилийн хугацаан дахь (2000-2040) хөгжлийн чиг хандлагыг судалж үзсэн болно. Яагаад заавал ийм урт 40 жилийн хугацааг тооцов гэхээр энэхүү загварчлалд гадаад донор орнуудаас монголд олгодог зээлийн ерөнхий нөхцөл нь 40 жилийн хугацаатай байдаг бөгөөд энэ хугацааг цикл гэж үзэн тооцсон болно. Жишээлбэл манай улс 2000 онд гадаадаас тодорхой хэмжээгээр зээл авлаа гэхэд энэхүү зээлийг 2040 оны дотор төлж дууссан байх ёстой гэсэн үг юм.

Аливаа улсын эдийн засаг хөгжих байна уу үгүй юу гэдгийг үзүүлэх нэг гол үзүүлэлт бол тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) бодит ёсөлт байдаг. Энэхүү загварчлалдаа монгол улсын эдийн засгийн хөгжлийн бодит ёсөлтийг 2000 оноос 2040 он хүртэлх хугацаанд жил болгон 5 хувь ёсөж байна гэж төсөөлж тооцож үзсэн бөгөөд үүн дээр үндэслэж Засгийн газрын хэрэглээ, хувийн хэрэглээ, хадгаламж, экспорт импортын хэмжээ зэрэг макро-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг төсөөлж гаргасан. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний ёсөлтийг ойрын хугацаанд 5-6 хувьд ёсех чиг хандлагатай гэж тооцсон бөгөөд негеэ талаар сүүлийн 2-3 жилийн хугацаан дахь энэхүү ёсөлт нь 5 хувь руу чиглэх хандлагатай байгаа юм. Негеэ талаас хөрш хоёр орон (Орос, Хятад)-ы эдийн засгийн хөгжлийн байдлыг тооцож үзсэн болно. Мөн загварчлал төсөөлөлийн тооцоондоо хоёр гол үзүүлэлт болох донор орнуудаас Монгол улсын засгийн газарт олгох засгийн газрын хөнгөлөлттэй зээл болон экспортын жилийн ёсөлтийн хэмжээг давхар төсөөлсөн. Өнгөрсөн 10 жилийн хугацаан дахь манай улсын Засгийн газрын гадаадаас авсан зээлийн хэмжээг тооцон үзэхэд жил болгон 100 –150 сая ам. долларын дундаж хэмжээнд, мөн экспортын жилийн ёсөлтийн хэмжээ нь дэлхийн зэсийн зах зээлийн үнээс хамаарч тогтвортой байсан. Энэ үүднээс гадаад зээлийн жил болгон ашиглах хэмжээг болон экспортын хэмжээг төсөөлөл хийж тооцсон.

Яагаад заавал энэ хоёр үзүүлэлтийг чухалчлан авч үзэж байна гэвэл эдийн засгийн ёсөлтийг хурдасгагч нэг гол хүчин зүйл бол гадаадын нөөц хөрөнгийг ашиглах явдал байдаг. Гадаадын нөөц хөрөнгө гэсэн ойлголтын хүрээнд гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг багтаан ойлгож болно. Мөн негеэ талаас экспортын ёсөлтийн хэмжээг байдаг. Энэ хоёр үзүүлэлтүүдийг төсөөлөл болгон хэдэн хувилбараар тооцож үзсэн болно.

Хүснэгт 2

Экспортын жил болгон ёсөлтийн хэмжээ жил болгон				
Гадаадын хөнгөлөлттэй зээлийн ашиглах хэмжээ ам. долларын төсөөлөл	4 хувь	5 хувь	6 хувь	7 хувь
1. Хамгийн багаар жилд 100 сая, ам. доллар	X	X	X	боломжтой
2. Багаар жилд 150 сая, ам. доллар	X	X	боломжтой	боломжтой
3. Дундажаар жилд 200 сая, ам. доллар	X	боломжтой	боломжтой	боломжтой
4. Хамгийн ихээр жилд 250 сая, ам. доллар	боломжтой	боломжтой	боломжтой	боломжтой

Хүснэгтэнд эхний баганад манай улсын засгийн газрын хөнгөлөлттэй гадаад зээлийн хэмжээг 4 хувилбараар авч үзсэн болно. Энэ нь нэгдүгээрт засгийн газар төсөөлөлийн хугацаанд жил болгон 100 сая ам.долларын гадаад хөнгөлөлттэй зээл авна гэсэн төсөөлөл бөгөөд хамгийн багаар тооцсон тооцоо. Хоёрдугаарт засгийн газар төсөөлөлийн хугацаанд жил болгон 150 сая ам.долларын гадаад хөнгөлөлттэй зээл авна гэсэн төсөөлөл бөгөөд багаар тооцсон тооцоо. Гуравдугаарт засгийн газар төсөөлөлийн хугацаанд жил болгон 200 сая ам.долларын гадаад хөнгөлөлттэй зээл авна гэсэн төсөөлөл бөгөөд дунджаар тооцсон тооцоо. Дөрөвдүгээрт засгийн газар төсөөлөлийн хугацаанд жил болгон 250 сая ам.долларын гадаад хөнгөлөлттэй зээл авна гэсэн төсөөлөл бөгөөд хамгийн ихээр тооцсон тооцоо болно.

Мөн хүснэгтийн хоёрдугаар баганад Монгол улсын экспортын жилийн дундаж өсөлтийг төсөөлсөн бөгөөд жил болгон 4 хувь өсөх, эсхүл жил болгон 5 хувь, эсхүл жил болгон 6 хувь өсөх, эсхүл жил болгон 7 хувь өсөх гэж тооцсон.

Дээрхи төсөөлөлүүд болон бусад хүчин зүйлүүд (тухайлбал, валютын ханшны өсөлт, татварын өсөлт зэрэг эдийн засгийн гол бусад үзүүлэлтүүд)-ийг харгалzan үзэхэд загварчлалын үр дүн нь дараах байдлаар гарч байна. Хүснэгт 1. Үүнд:

- Хэрэв Монгол улсын Засгийн газар хандивлагч орнуудаас авах гадаад зээлийг 100 сая ам.долларын хэмжээнд авах юм бол экспортын бодит өсөлтийг жил болгон 7 хувиар өсгөх шаардлагатай байгаа бөгөөд ингэвэл төсөөлөл хийсэн хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувийн өсөлтийг хангаж болно гэсэн үг.
- Нөгөө талаар хэрэв Монгол улсын Засгийн газар экспортын хэмжээг жил болгон 4 хувь өсгөх юм бол хандивлагч орнуудаас авах гадаад зээлийн хэмжээг жил болгон 250 сая ам.долларын түвшинд хүргэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.
- Эцэст нь Монгол улсын засгийн газар хандивлагч орнуудаас 200 сая ам.долларын гадаад зээлийг авч чадахгүй, зөвхөн 150 сая ам.долларын зээлийг авах юм бол экспортын жилийн бодит өсөлтийг ядаж 6 хувьд хүргэх шаардлагатай юм.

Гурав. Засгийн газарт өгөх эдийн засгийн бодлогын талаархи зөвлөмж

Дээрхи загварчлалын үр дүнгээс хараад дараах дүгнэлт гарч байгаа бөгөөд эндээс Засгийн газар дараах бодлогуудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй болов уу.

- Монголд хандивлагч орнуудаас жил болгон ядаж 150 сая ам.долларын зээлийг авч байх шаардлагатай бөгөөд мөн экспортын хэмжээг жил болгон 6 хувиар өсгөх хэрэгтэй. Мэдээж гадаад зээлийн ашиглалтын хэмжээг үүнээс илүү өсгөх асуудал

монголын талын шийдэх асуудал биш бөгөөд хандивлагч орнуудын шийдвэрээс ихээхэн хамааралтай. Хэрвээ жил болгон ийм хэмжээний гадаад зээл авбал энэхүү зээлийг экспортыг хөгжүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулах хэрэгтэй бөгөөд эргээд төлбөр хийхэд ч үр ашигтай байх болов уу.

- Засгийн газар жил болгон экспортын 6 хувь хэмжээг өсгөхдөө зэсийн баяжмал, алт, ноолуур мах, савхины чиглэлийн экспортын хэмжээг өсгөх, мөн жуулчлалын салбарыг хөгжүүлэх чиглэл баримтлах зүйтэй. Ингэхдээ 2000-2040 оны хугацаанд эдгээр чиглэлийн экспортын хэмжээг өсгөхдөө дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт буюу стратегийн бодлоготой нарийн уялдуулан тооцож тодорхой хувиар өсгөх хэрэгтэй.

Энэхүү эдийн засгийн загварчлал нь Монгол улсын макро-эдийн засгийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөний зөвхөн нэг жишээ загвар бөгөөд холбогдох нарийн тооцоонууд дээр үндэслэгдэж хийгдсэн болно.